



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ерөнхий боловсролын Сод эрдэм сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ХӨА-2022/228/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг

2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ

Утас: 88090438 Цахим хаяг: [baterdenee@audit.gov.mn](mailto:baterdenee@audit.gov.mn)

Ахлах аудитор: Г.Эрдэнэчимэг

Утас: 99016320 Цахим хаяг: [erdenechimegg@audit.gov.mn](mailto:erdenechimegg@audit.gov.mn)

Төгс суурь стандарт аудит ХХК-ийн

Ерөнхий захирал: Т.Батсайхан

Утас: 99010760 Цахим хаяг: [tcc.audit.mn@gmail.com](mailto:tcc.audit.mn@gmail.com)

Аудитын менежер: Г.Оюунгэрэл

Утас: 77551229 Цахим хаяг: [tcc.audit.mn@gmail.com](mailto:tcc.audit.mn@gmail.com)

Ахлах аудитор: Д.Алтайбаяр

Утас: 77551229 Цахим хаяг: [tcc.audit.mn@gmail.com](mailto:tcc.audit.mn@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	<b>Error! Bookmark not defined.</b>
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.6.1 Төсвийн төлөвлөлт.....	13
3.6.2 Төсвийн гүйцэтгэл .....	13
3.6.3 Нэмэлт төсөв .....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал .....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт .....	16
4.1 Залруулсан алдаа .....	16
4.2 Төлбөрийн акт.....	16
4.3 Албан шаардлага .....	16
Аудитын зөвлөмж.....	16

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
ЭЕШ	Элсэлтийн ерөнхий шалгалт



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.25 № 01/185  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН "СОД ЭРДЭМ"  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Д.МӨНХБААТАР ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Ерөнхий боловсролын "Сод эрдэм" сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Ерөнхий боловсролын "Сод эрдэм" сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

  
1728870001.1.0070605

А.ЭРДЭНЭБААТАР

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>92,621,248.61</b>	<b>137,535,184.16</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>3,668,600.00</b>	<b>00.00</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,668,600.00	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>88,952,648.61</b>	<b>137,535,184.16</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>4,059,707.00</b>	<b>5,319,087.00</b>
35130	Эм боох материал	4,059,707.00	5,319,087.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>84,892,941.61</b>	<b>132,216,097.16</b>
35410	Бичиг хэргийн материал	5,785,843.00	11,661,834.55
35420	Аж ахуйн материал	10,429,302.00	14,724,190.00
35450	Барилгын засварын материал	00.00	3,247,300.00
35470	Бусад хангамжийн материал	68,677,796.61	102,582,772.61
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,281,453,712.11</b>	<b>5,360,933,885.18</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>5,281,453,712.11</b>	<b>5,360,933,885.18</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>5,062,867,883.37</b>	<b>5,143,643,889.14</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,931,568,150.00	4,931,568,150.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-172,298,284.68	-258,920,427.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	235,701,964.55	283,708,281.43
39206	Хуримтлагдсан элэгдэл	-102,483,181.08	-48,367,012.93
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	141,986,412.25	183,782,337.30
39208	Хуримтлагдсан элэгдэл	-71,413,601.39	-74,906,281.19
39214	Бусад үндсэн хөрөнгө	70,560,250.00	95,410,250.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-7,725,999.84	-9,529,799.76
39217	Ном	36,972,173.56	40,898,391.29
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>218,585,828.74</b>	<b>217,289,996.04</b>
39301	Програм хангамж	11,763,745.00	11,653,745.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,077,916.26	-3,263,748.96
39303	Бусад биет бус хөрөнгө	208,900,000.00	208,900,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>5,374,074,960.72</b>	<b>5,498,469,069.34</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,334,445.00</b>	<b>00.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,334,445.00</b>	<b>00.00</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>2,334,445.00</b>	<b>00.00</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,334,445.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>5,371,740,515.72</b>	<b>5,498,469,069.34</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>5,371,740,515.72</b>	<b>5,498,469,069.34</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	208,900,000.00	208,900,000.00
51101	Өмч: - төрийн	208,900,000.00	208,900,000.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>5,162,840,515.72</b>	<b>5,289,569,069.34</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	5,162,840,515.72	5,162,840,515.72
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	126,728,553.62
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>5,374,074,960.72</b>	<b>5,498,469,069.34</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,711,085,089.91</b>	<b>1,910,177,454.34</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>24,238,389.91</b>	<b>115,220,597.79</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>24,238,389.91</b>	<b>115,220,597.79</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	24,238,389.91	115,220,597.79
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	24,238,389.91	115,220,597.79
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>257,882,000.00</b>	<b>1,794,956,856.55</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,428,964,700.00	1,525,194,200.00

<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>3,838,300.00</b>	<b>18,263,256.55</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	2,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	13,120,156.55
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,838,300.00	3,143,100.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>254,043,700.00</b>	<b>251,499,400.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	254,043,700.00	251,499,400.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,674,153,384.72</b>	<b>1,770,509,000.72</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,674,153,384.72</b>	<b>1,770,509,000.72</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,631,917,060.72</b>	<b>1,702,721,800.62</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,074,259,545.00</b>	<b>1,103,876,853.90</b>
210101	Үндсэн цалин	857,625,763.10	727,321,355.00
210102	Нэмэгдэл	119,492,909.37	311,783,500.90
210104	Урамшуулал	97,140,872.53	64,771,998.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>137,091,200.00</b>	<b>144,358,301.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	91,654,100.00	101,091,968.97
210202	Тэтгэмжийн даатгал	11,359,391.00	11,109,966.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,087,400.00	8,844,292.05
210204	Ажилгүйдлийн даатгал	2,271,900.00	2,119,278.63
210205	Эрүүл мэндийн даатгал	22,718,409.00	21,192,794.98
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>235,881,576.00</b>	<b>244,410,800.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,070,776.00	5,840,000.00
210302	Түлш, халаалт	224,410,800.00	230,410,800.00
210303	Цэвэр, бохир ус	6,400,000.00	8,160,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>17,875,718.00</b>	<b>20,303,442.00</b>
210401	Бичиг хэрэг	210,000.00	150,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,080,000.00	810,000.00
210404	Ном, хэвлэл	4,161,500.00	3,364,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,505,838.00	240,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,418,380.00	15,239,042.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>3,028,293.00</b>	<b>4,597,720.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,528,293.00	4,597,720.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>11,600,830.00</b>	<b>18,584,770.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	12,449,640.00
210604	Урсгал засвар	11,600,830.00	6,135,130.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,048,400.00</b>	<b>00.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,048,400.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,873,900.00</b>	<b>2,908,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,273,900.00	1,900,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	1,008,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>149,257,598.72</b>	<b>163,681,913.72</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,417,480.00	24,376,343.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	135,840,118.72	139,305,570.72
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>42,236,324.00</b>	<b>67,787,200.10</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>25,981,300.00</b>	<b>57,680,000.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	23,989,800.00	57,180,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,991,500.00	500,000.00

2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>12,725,800.00</b>	<b>10,107,200.10</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,725,800.00	10,107,200.10
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>3,529,224.00</b>	<b>00.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,529,224.00	00.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>36,931,705.19</b>	<b>139,668,453.62</b>
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>12,939,900.00</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	12,939,900.00
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>00.00</b>	<b>-12,939,900.00</b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>36,931,705.19</b>	<b>126,728,553.62</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	208,900,000.00	5,125,908,810.53	5,334,808,810.53
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	208,900,000.00	5,125,908,810.53	5,334,808,810.53
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	36,931,705.19	36,931,705.19
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	208,900,000.00	5,162,840,515.72	5,371,740,515.72
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	208,900,000.00	5,162,840,515.72	5,371,740,515.72
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	208,900,000.00	5,162,840,515.72	5,371,740,515.72
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	126,728,553.62	126,728,553.62
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	208,900,000.00	5,289,569,069.34	5,498,469,069.34

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,686,846,700.00</b>	<b>1,794,956,856.55</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,686,846,700.00</b>	<b>1,794,956,856.55</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,428,964,700.00	1,525,194,200.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>3,838,300.00</b>	<b>18,263,256.55</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	2,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	13,120,156.55
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,838,300.00	3,143,100.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>254,043,700.00</b>	<b>251,499,400.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	254,043,700.00	251,499,400.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,584,733,557.00</b>	<b>1,655,220,236.55</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,584,733,557.00</b>	<b>1,655,220,236.55</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,542,497,233.00</b>	<b>1,587,433,036.45</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,075,593,700.00</b>	<b>1,102,542,698.90</b>
210101	Үндсэн цалин	858,959,918.10	725,987,200.00
210102	Нэмэгдэл	119,492,909.37	311,783,500.90
210104	Урамшуулал	97,140,872.53	64,771,998.00

<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>137,091,200.00</b>	<b>144,358,301.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	91,654,100.00	101,091,968.97
210202	Тэтгэмжийн даатгал	11,359,300.00	11,109,966.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,087,400.00	8,844,292.05
210204	Ажилгүйдлийн даатгал	2,271,900.00	2,119,278.63
210205	Эрүүл мэндийн даатгал	22,718,500.00	21,192,794.98
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>235,881,576.00</b>	<b>244,410,800.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,070,776.00	5,840,000.00
210302	Түлш, халаалт	224,410,800.00	230,410,800.00
210303	Цэвэр, бохир ус	6,400,000.00	8,160,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>29,614,900.00</b>	<b>37,003,096.55</b>
210401	Бичиг хэрэг	948,900.00	3,885,394.55
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,080,000.00	810,000.00
210404	Ном, хэвлэл	4,850,700.00	4,565,640.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,369,100.00	710,062.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,866,200.00	26,532,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>8,025,200.00</b>	<b>4,219,600.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,823,000.00	3,010,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,202,200.00	1,209,300.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>23,494,757.00</b>	<b>32,525,240.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,336,857.00	25,436,640.00
210602	Тавилга	6,305,000.00	00.00
210604	Урсгал засвар	13,852,900.00	7,088,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,048,400.00</b>	<b>00.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,048,400.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,913,900.00</b>	<b>5,298,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,313,900.00	4,290,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	1,008,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>29,833,600.00</b>	<b>17,075,300.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	29,833,600.00	17,075,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>42,236,324.00</b>	<b>67,787,200.10</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>25,981,300.00</b>	<b>57,680,000.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	23,989,800.00	57,180,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,991,500.00	500,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>12,725,800.00</b>	<b>10,107,200.10</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,725,800.00	10,107,200.10
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>3,529,224.00</b>	<b>00.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,529,224.00	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>102,113,143.00</b>	<b>139,736,620.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>102,113,143.00</b>	<b>139,736,620.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>102,113,143.00</b>	<b>139,736,620.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>102,113,143.00</b>	<b>139,736,620.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	102,113,143.00	139,736,620.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-102,113,143.00</b>	<b>-139,736,620.00</b>

7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	-
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,776,693,600.0	1,766,586,399.9	10,107,200.1	99.4
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,776,693,600.0	1,766,586,399.9	10,107,200.1	99.4
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,713,391,400.0	1,708,906,399.9	4,485,000.1	99.7
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,102,542,900.0	1,102,542,698.9	201.1	100.0
210101	Үндсэн цалин	723,987,200.0	725,987,200.0	-2,000,000.0	100.3
210102	Нэмэгдэл	314,255,700.0	311,783,500.9	2,472,199.1	99.2
210104	Урамшуулал	64,300,000.0	64,771,998.0	-471,998.0	100.7
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	148,843,000.0	144,358,301.0	4,484,699.0	97.0
210201	Тэтгэврийн даатгал	104,741,500.0	101,091,969.0	3,649,531.0	96.5
210202	Тэтгэмжийн даатгал	11,025,400.0	11,109,966.4	-84,566.4	100.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,820,300.0	8,844,292.1	-23,992.1	100.3
210204	Ажилгүйдлийн даатгал	2,205,100.0	2,119,278.6	85,821.4	96.1
210205	Эрүүл мэндийн даатгал	22,050,700.0	21,192,795.0	857,905.0	96.1
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	244,410,800.0	244,410,800.0	00.0	100.0
210301	Гэрэл, цахилгаан	6,320,000.0	5,840,000.0	480,000.0	92.4
210302	Түлш, халаалт	230,410,800.0	230,410,800.0	00.0	100.0
210303	Цэвэр, бохир ус	7,680,000.0	8,160,000.0	-480,000.0	106.3
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	41,707,700.0	41,707,700.0	00.0	100.0
210401	Бичиг хэрэг	3,280,200.0	3,280,200.0	00.0	100.0
210402	Тээвэр, шатахуун	500,000.0	500,000.0	00.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	810,000.0	810,000.0	00.0	100.0
210404	Ном, хэвлэл	10,745,400.0	10,745,400.0	00.0	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	390,100.0	390,100.0	00.0	100.0

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	25,982,000.0	25,982,000.0	00.0	100.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	4,069,600.0	4,069,600.0	00.0	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,860,300.0	2,860,300.0	00.0	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,209,300.0	1,209,300.0	00.0	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	145,033,600.0	145,033,600.0	00.0	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	123,595,000.0	123,595,000.0	00.0	100.0
210602	Тавилга	14,350,000.0	14,350,000.0	00.0	100.0
210604	Урсгал засвар	7,088,600.0	7,088,600.0	00.0	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	100.0	00.0	100.0	00.0
210702	Дотоод албан томилолт	100.0	00.0	100.0	00.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,698,400.0	4,698,400.0	00.0	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,690,400.0	3,690,400.0	00.0	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.0	1,008,000.0	00.0	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	22,085,300.0	22,085,300.0	00.0	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,085,300.0	22,085,300.0	00.0	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	63,302,200.0	57,680,000.0	5,622,200.0	91.1
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	63,302,200.0	57,680,000.0	5,622,200.0	91.1
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	62,802,200.0	57,180,000.0	5,622,200.0	91.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.0	500,000.0	00.0	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,776,693,600.0	1,776,693,600.0	00.0	100.0
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,525,194,200.0	1,525,194,200.0	00.0	100.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,525,194,200.0	1,525,194,200.0	00.0	100.0
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	251,499,400.0	251,499,400.0	00.0	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	251,499,400.0	251,499,400.0	00.0	100.0

62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	92.00	92.00	00.0	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	67.00	67.00	00.0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	24.00	24.00	00.0	100.0
65	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	92.00	92.00	00.0	100.0
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	68.00	68.00	00.0	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	24.00	24.00	00.0	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>18,263,256.55</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>18,263,256.55</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>18,263,256.55</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,513,256.55</b>
210401	Бичиг хэрэг	605,194.55
210404	Ном, хэвлэл	3,038,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	319,962.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	550,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>150,000.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	150,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>10,850,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,850,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,750,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,750,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>18,263,256.55</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>18,263,256.55</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,970,156.55
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,293,100.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>00.00</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ерөнхий боловсролын Сод эрдэм сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төгс суурь стандарт аудит ХХК-ийн чанарын хяналтын менежер Г.Оюунгэрэл, аудитор Г.Мөнхбаяр нар гүйцэтгэж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах ХӨА-2022/228/НА-СТА-ТШЗ

аудитор Г.Эрдэнэчимэг, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ нар анхан шатанд чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хоёр дахь шатны хяналтыг хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ерөнхий боловсролын Сод эрдэм сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төгс суурь стандарт аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 09 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ерөнхий боловсролын Сод эрдэм сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Багш, ажилтны мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжиж, хүүхэд бүрийг хөгжүүлэх арга барилд сургаж, ёс зүйгээр манлайлагч, бүтээлч, чадварлаг хамт олныг бүрдүүлэн төлөвшүүлэх” гэж тодорхойлжээ.

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ерөнхий боловсролын Сод эрдэм сургуулийн 2021 оны үйл ажиллагааны чиглэл нь:

1. Хосолсон сургалтын хэлбэрийг амжилттай хэрэгжүүлэх
2. Багшийн хөгжил дэд хөтөлбөр
3. Нэг багш-Нэг дугуйлан дэд хөтөлбөр
4. Хамгаалагдсан хүүхэд дэд хөтөлбөр
5. Альфа математикийн дэд хөтөлбөр
6. Сайн хичээл дэд хөтөлбөр
7. ЭЕШ-800 дэд хөтөлбөр
8. Математик, Англи хэлний гүнзгий сургалтын хөтөлбөр
9. Success англи хэлний дэд хөтөлбөр
10. Олимпиад-Мэдлэг дэд хөтөлбөр
11. Ээлтэй сургууль дэд хөтөлбөр
12. Зорилтот бүлгийн сурагчдыг чадваржуулан хөгжүүлэх “Алхам алхамаар” технологи
13. “Миний гоёхон дэвтэр” технологийг боловсруулан хэрэгжүүлэн ажиллаж байна

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн 1 дүгээр зүйл. “Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.7" хувьд өөрчлөлт орж "11.7" хувь, Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.5" хувьд өөрчлөлт орж "11.5" хувь болж өөрчлөгдсөн байна.
- Монгол улсын Засгийн газрын 2021 онд баталсан Үдийн хоолны норматив тогтоох тухай 237 дугаар тогтоолын 1-д “Мөрөн сумын ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн нэг хүүхдэд ногдох үдийн хоолны зардлын нормативыг 2021 оны 9-р сарын 1-ний өдрөөс 1500 төгрөг”-өөр тогтоосугай гэж заасныг хэрэгжүүлж ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналтын комисс нь үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө гарган, улиралд нэг удаа хяналт хийж, тайланг захирлын зөвлөлд танилцуулж шийдвэрлүүлдэг ба төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналыг баримтжуулсан байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ерөнхий боловсролын Сод эрдэм сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн 1.5 хувиар буюу 25.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 20.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн нийт зардал 1,770.5 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 26.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80-хувиар буюу 21.2 сая төгрөгөөр тооцлоо. Энэ нь суурь үзүүлэлтийн дүн өмнөх оноос өссөнтэй холбоотой.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ерөнхий боловсролын Сод эрдэм сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 124.4 сая төгрөгөөр буюу 2.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүнгийн данс байна.

Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлтийг хүснэгтээр харуулав.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/сая төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Дансны авлага	3.7	0	-3.7
Бараа материал	88.9	137.5	48.6
Биет хөрөнгө	5281.5	5360.9	79.5
Биет бус хөрөнгө	218.6	217.3	-1.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>5,374.1</b>	<b>5,498.5</b>	124.4
Дансны өглөг	2.3	0	-2.3
<b>Эздийн өмч</b>	<b>208.9</b>	<b>208.9</b>	0
-төрийн	208.9	208.9	0
Хуримтлагдсан үр дүн	5,162.8	5,289.6	126.7
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>5,374.1</b>	<b>5,498.5</b>	124.4

Мөнгөн хөрөнгө, авлага, өр төлбөрийн данс нь оны эцэст үлдэгдэл байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 48.6 сая төгрөгөөр өссөн байна. Үүнд нөлөөлсөн материаллаг өөрчлөлт нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 77.7 сая төгрөг, БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 20.6 сая төгрөгийн эм бэлдмэл болон бусад хангамжийн материалыг

авсан, Аймгийн ЗДТГ-аас үнэ төлбөргүй хүлээн авсан эм боох материал 2.6 сая төгрөг нийт 101.0 сая төгрөгийн бараа материалын өсөлтөөс шалтгаалжээ.

Биет хөрөнгө дансны үлдэгдэл 79.5 сая төгрөгөөр өсөж 5,360.9 сая төгрөг болсон байна. Үүнд нөлөөлсөн материаллаг өөрчлөлт нь төсвийн хөрөнгөөр худалдаж 139.7 сая төгрөг, БШУЯ-аас хандиваар авсан номын фонд, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил 43.8 сая төгрөг, Мөрөн сумын ИТХ-ын А88 тушаалаар 47.1 сая төгрөгийн биет хөрөнгө дахин үнэлж бүртгэснээс шалтгаалжээ.

Биет бус хөрөнгийн дүн өнгөрсөн оноос 1.3 сая төгрөгөөр буурсан нь Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 111 дугаар тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 0.9 сая төгрөгийн программ хангамжийг данснаас хассантай холбоотой байна.

Хуримтлагдсан үр дүнгийн үлдэгдэл 126.7 сая төгрөгөөр өссөн шалгаан нь “0” үлдэгдэлтэй хөрөнгийг данснаас хасаж дахин үнэ тогтоон бүртгэлт тусгасан нь нөлөөлсөн байна.

Нийт зардал өмнөх оноос 96.4 сая төгрөгөөр буюу 5.4 хувиар өссөн байна. Үүнд:

- Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал халдваргүйжүүлэлтийн зардал, бага боловсролын бүлэг нэмэгдсэнээс үүдэн багш 2 орон тоогоор нэмж ажилласан.
- “Хоол үйлдвэрлэлийн тухай шинэ хууль хэрэгжиж эхэлснээр үдийн цай төслийг нь үдийн хоол болгож өөрчлөхтэйгээр холбоотойгоор бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлийн зардал өссөн.
- Кабинет шинээр үүсгэн байгуулж, тохижуулахтай холбоотой эд хогшил, урсгал засварын зардал өссөн.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,824.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж Боловсролын газарт хүргүүлсэн. Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн саналаас 203.9 сая төгрөгөөр бууруулж 1,620.8 сая төгрөгөөр баталж 2 удаагийн тодотгол орж улсын төсвөөс 1,525.2 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 251.5 сая төгрөгөөр нийт 1,776.7 сая төгрөгөөр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

2021 онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 6 зориулалт арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,776.7 сая төгрөгийн төсөв батлагдсан. Гүйцэтгэлээр 1,766.6 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулж, 10.1 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ерөнхий боловсролын Сод-Эрдэм сургууль нь дараах хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үүнд:

Хөтөлбөр: 71802 Ерөнхий боловсрол

- Зориулалт арга хэмжээ: 81834 –Боловсролын стандарт сургалтын төлөвлөгөө хөтөлбөр хэрэгжүүлэх
- 81835 – Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах
- 80109 – ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал
- 81801 – Үдийн цай хөтөлбөр

80802 - Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал

Хөтөлбөр: 71807 Тусгай хэрэгцээт боловсрол

Зориулалт арга хэмжээ: 81834 –Боловсролын стандарт сургалтын төлөвлөгөө хөтөлбөр хэрэгжүүлэх

Хөтөлбөр арга хэмжээний зардлыг хүснэгтээр харуулав.

Хүснэгт 2. Хөтөлбөр арга хэмжээний зардлын хүснэгт

/сая.төгрөг/

Хөтөлбөр арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
71802	Ерөнхий боловсрол				
81834	Боловсролын стандарт сургалтын төлөвлөгөө хөтөлбөр хэрэгжүүлэх	1,145.9	1,141.4	4.5	99.6
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	304.1	304.1	0.0	100.0
80109	ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал	251.5	251.5	0.0	100.0
81801	Үдийн цай хөтөлбөр	62.8	57.2	5.6	91.1
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	0.5	0.5	0.0	100.0
71807	Тусгай хэрэгцээт боловсрол				
81834	Боловсролын стандарт сургалтын төлөвлөгөө хөтөлбөр хэрэгжүүлэх	11.9	11.9	0.0	100.0

Нийт хөтөлбөрийн биелэлтийг 98.4 хувиар үнэлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийг хөтөлбөр тус бүрээр харуулав

Хүснэгт 3. Нэмэлт санхүүжилтийг хөтөлбөр тус бүрийн хүснэгт

/сая.төгрөг/

№	Орлого			Зарлага	Үлдэгдэл	Төвлөр үүлсэн
	Байгууллага	Зориулалт	Дүн			
1	БШУЯ	Түрээсийн сурах бичиг	3.0	3.0	0.0	0.0
2	Боловсролын газар	Ариутгал, халдваргүйжүүлэл	0.3	0.3	0.0	0.0
3	Мөрөн сум ЗД нөөц	Халдваргүйжүүлэлт	2.0	2.0	0.0	0.0
4	БШУЯ	Боловсролын чанарын шинэчлэл төсөл	10.6	10.6	0.0	0.0
5	Боловсролын үнэлгээний төв	Үнэлгээ тогтоох бичиг хэргийн зардал	0.5	0.5	0.0	0.0
6	Аймгийн ЗДТГ	ХАБ-ын шилдэг байгууллага	0.3	0.3	0.0	0.0
7	Аймгийн ЭМГ	Дэмжигч байгууллагын шагнал	0.2	0.2	0.0	0.0
8	Аймгийн ЗДТГ	Халдваргүйжүүлэлт	1.3	1.3	0.0	0.0
9	Сод эрдэм ЕБС	Тендерийн орлого	0.1	0.1	0.0	0.0
ДҮН			18.3	18.3	0.0	0.0

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлого төвлөрүүлээгүй ба орсон орлогыг зориулалтыг дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүссэн болон аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал гараагүй болно.

Улсын болон орон нутгийн онцгой комиссын шийдвэрээр хөл хорио тогтоосны улмаас сургалтын хэвийн үйл ажиллагаа хязгаарлагдаж байсан.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Төсөв санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас батлагдсан төсвийг тайлбар тодруулга авахгүй төсвийг үндэслэлгүй хасаж төрийн сангийн системд оруулж байгааг цаашид анхаарах шаардлагатай.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ерөнхий боловсролын Сод эрдэм сургууль нь 2021 онд нийт 2,896.5 сая төгрөгийн 98 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод, бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Аудитаар Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж баталгаажуулав. Үүнд:

- Үдийн хоолны норматив тогтоох тухай Монгол улсын Засгийн газрын 2021 оны 237 дугаар тогтоолоор Мөрөн сумын ерөнхий боловсролын сургуулийн нэг хүүхдэд ногдох үдийн хоолны нормативд зардлыг хэтрүүлээгүй нь уг тогтоолын холбогдох заалттай нийцсэн байна.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын бүртгэл тайлагнал, шилэн дансны мэдээлэлтэй холбоотой 2 зөвлөмж өгсөн байна. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн биелүүлсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитын цар хүрээ хязгаарлагдаж, байгууллага дээр ажиллах нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн, анхан шатны баримт материалуудыг бүрэн хамруулж, хөрөнгийн биет тооллого хийх хяналтыг бүрэн хэрэгжүүлэх

нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

#### **4. Аудитын илрүүлэлт**

---

Аудитаар алдаа зөрчил гараагүй болно.

##### **4.1 Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай асуудал илрээгүй тул залруулга хийгдээгүй болно.

##### **4.2 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

##### **4.3 Албан шаардлага**

Албан шаардлага хүргүүлээгүй болно.

#### **Аудитын зөвлөмж**

---

Аудитаар зөвлөмж өгөөгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.